

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА С.БАТЖАРГАЛ

2020 оны 12 дугаар сарын 30 -ны өдөр

БАТЛАВ

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ - 2

2020 оны 12 дугаар сарын 30 -ны өдөр



### ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

Дугаар: 2020/02

Энэхүү гэрээг нэг талаас Орхон аймгийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) , нөгөө талаас ашигт малтмалын үүсмэл ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Ачит-Ихт” ХХК (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх), Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцож 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү гэрээ нь Орхон аймгийн Баян- Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэрт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчин, хүн амд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор компанийн эдийн засгийн эрх ашгийг хөндөхгүйгээр үйл ажиллагааны тогтвортой, хэвийн үргэлжлүүлэх байдлыг баталгаажуулах асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн тусгай зөвшөөрөл бүхий нутаг дэвсгэрт байгаль орчныг хамгаалах, орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, компанийн хооронд ил тод, нээлттэй, шударга, олон талт харилцааг хөгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр дэмжлэг үзүүлж ажиллана.

1.3.Гэрээний талууд гэрээг тайлбарлах, хэрэгжүүлэхдээ дараах зарчмуудыг хүндэтгэн дагаж мөрдөхөөр хүлээн зөвшөөрөв:

- хууль дээдлэх;
- ил тод, нээлттэй байх;
- талууд эрх тэгш байх;
- шударга ёсыг сахих;
- харилцан хүндэтгэлтэй байх;
- иргэдийн оролцоог хангах;
- гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлэх.

#### Хоёр. Засаг даргын эрх, үүрэг

2.1.Засаг дарга дараах эрхийг эдэлнэ:

2.1.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, биелүүлэхийг шаардах;

2.1.2. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч болон иргэн, аж ахуйн нэгж, бусад байгууллагын үүргийн биелэлтэд хяналт тавьж, буруутай этгээдэд өөрийн эрх хэмжээний хүрээнд хариуцлага тооцох;

2.1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих

2.2. Засаг дарга дараах үүргийг хэрэгжүүлнэ:

2.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжийнд дагуу шийдвэрлэж, хариуг хүргүүлэх;

2.2.2. Гэрээний зорилго, мөн чанар, агуулга, ач холбогдлыг орон нутгийн иргэдэд таниулан ойлгуулах, орон нутгийн ард иргэдийн саналыг гэрээг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгах;

2.2.3. Хууль тогтоомжийн хүрээнд үүсмэл орд ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангахад дэмжлэг үзүүлэх;

2.2.4. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төсөл, арга хэмжээг түүнтэй зөвшилцсөний үндсэн дээр сонгон хэрэгжүүлэх;

2.2.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсан талаарх мэдээллийг Геологи уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд, харьяа нутаг дэвсгэрийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд ажлын 5 хоногийн дотор хүргүүлэх.

Гурав. **Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг**

3.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрхийг эдэлнэ:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний чиглэлийг өөрийн үйл ажиллагааны бодлогод нийцүүлэн сонгох;

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;

3.2.2. Нийт ажлын байрны 80-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг ажиллуулах;

3.2.3. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар тухайн аймаг, сумын иргэдийг тогтмол буюу хагас жилд нэгээс доошгүй удаа мэдээллээр хангах;

3.2.4. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй, зохих шаардлагыг хангасан татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгох;

3.2.5. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;



3.2.6.Гамшиг, аюултай үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед тухайн орон нутагт ажиллах хүн хүч, техник, тоног төхөөрөмж, мөнгөн хөрөнгө болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх;

3.2.7.Байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж, орон нутагт үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэх.

#### **Дөрөв. Хамтын ажиллагааны хороо**

4.1.Талуудын гэрээ байгуулах явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г аймгийн Засаг дарга, Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж, ажиллуулна.

4.2.Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангаж, Баянцагаан багийн Иргэдийн Нийтийн Хурлаас нэг иргэнийг дэвшүүлэн, хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3.Хороо нь жил бүрийн 2 дугаар сарын 1-ний дотор тухайн жил хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гарган, гэрээ байгуулагч талуудад хүргүүлнэ.

#### **Тав. Гэрээний хэрэгжилт**

5.1.Талууд гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээллэж, гэрээ, түүнтэй холбоотой баримт бичгийг цахим хуудсандаа байршуулна.

5.2.Гэрээний хуулбар хувийг ажлын 5 хоногийн дотор үйл ажиллагаа явуулж буй харьяа нутаг дэвсгэрийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.3.Талууд жил бүрийн хамтын ажиллагааны төлөвлөгөөг батлах бөгөөд төлөвлөгөө нь гэрээний салшгүй хэсэг байна.

5.4.Гэрээний хэрэгжилтэд талууд харилцан хяналт тавьж, төлөвлөгөөний биелэлтийг жил бүр дүгнэж, гэрээний хэрэгжилтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 01-ний дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлнэ.

#### **Зургаа. Хариуцлага**

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2.Талууд гэрээний хэрэгжилттэй холбогдсон маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд тохиролцоонд хүрч чадаагүй тохиолдолд гомдлоо шүүхэд гаргаж болно.

#### **Долоо. Бусад**

7.1.Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 4 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх ба жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

7.2.Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэнэ. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт энэ гэрээний салшгүй хэсэг бөгөөд нэгэн адил хүчинтэй байна.

7.3.Гэрээний хугацаа дуусахад аль нэг талаас гэрээг дуусгавар болгох талаар санал ирүүлээгүй бол энэ гэрээ дахин нэг жилээр сунгагдсанд тооцно.

7.4.Гал түймэр, цахилгааны болон бусад техник хэрэгслийн саатал, үер, хүчтэй аадар бороо, мөндөр, салхи шуурга, газар хөдлөлт, онц байдал, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, гоц халдварт өвчний улмаас тогтоосон хөл хорио гэх мэт давагдашгүй хүчин зүйлс бий болсон тохиолдолд түүнийг арилгах хүртэл гэрээний үүргийн биелэлтийг хойшлуулж болно.

7.5.Гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэх бөгөөд талууд тус бүр нэг хувийг хадгална.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ОРОН НУТГИЙН ЗАХИРГААГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ М.ТҮМЭНЖАРГАЛ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА М.МӨНХБАЯР

САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА Н.БЯМБАЦЭЦЭГ

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,  
ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

С.ДАВААДОРЖ

2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр

Хаяг:

Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,  
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон  
Утас: 7035 9910, Факс: (976) 7035 2621

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ  
БАЙГУУЛЛАГЫГ ТӨЛӨӨЛЖ:

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ҮЙЛДВЭРИЙН  
ЗАХИРЛЫН ЗӨВЛӨХ

Л.ЦЭДЭНСОДНОМ

“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ЗАХИРГААНЫ  
МЕНЕЖЕР

Б.БАДРАХ-ЭРДЭНЭ

2020 оны 12 дугаар сарын 30-ны өдөр


Хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
15-р хороо, Стадион оргил-1,  
Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би  
Тауэр, 21 давхар  
Утас: 7595 1199, 7595 1155



БАТЛАВ: ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА С.БАТЖАРГАЛ

БАТЛАВ: "АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ОРХОН АЙМАГ, "АЧИТ-ИХТ" ХХК-ИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ  
2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2021 оны 03 дугаар сарын 26 өдөр

Орхон аймаг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	Хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Төсөв /сая төгрөг/	Хүрэх үр дүн
<b>Байгаль орчныг хамгаалах чиглэлээр:</b>						
1.	Бурхан багшийн сэрэг дүр орчмын урд талын 5 га газарт цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын зураг төсөл хийх, эхлүүлэх	Жилдээ	"Ачит-Ихт" ХХК-ийн үйлдвэрийн ХАБЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан, Захиргааны менежер Б.Бадрах-Эрдэнэ	ХОХБТХ-ийн дарга С.Даваадорж БОАЖГ-ын дарга С.Жаргалсайхан	80.0	Цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв хийгдэж, төсөл хэрэгжиж эхэлсэн байна.
2.	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хүрээнд Бүрэнбүстийн хөв цөөрмийг доторлох ажлыг дуусгах	Жилдээ	"Ачит-Ихт" ХХК-ийн үйлдвэрийн ХАБЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан, Захиргааны менежер Б.Бадрах-Эрдэнэ	ХЗА-ны дарга С.Ганцогт	20.0	Бүрэнбүстийн хөв цөөрөм доторлох ажлыг дуусгасан байна.
3.	Бүрэнбүстийн унд, ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн мониторингийн цооног гаргах	Жилдээ	"Ачит-Ихт" ХХК-ийн Үйлдвэрийн ХАБЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан	СГСГЗахиргааны дарга М.Чулуунзагд	16.0	Бүрэнбүстийн унд ахуйн ус хангамжийн эх үүсвэр усны даралт, түвшин, температур, цахилгаан дамжуулах чадвар зэрэг үзүүлэлтүүдээр хянагдаж эхэлнэ.



**Боловсрол, хүүхэд залуусын хөгжил чиглэлээр:**

4.	Ерөнхий боловсролын сургуулийн химийн лабораторийг бүрэн тохижуулах	жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн Захиргааны менежер Б.Бадрах-Эрдэнэ	НБХ-ийн дарга А.Бумансор	45.0	Ерөнхий боловсролын 1 сургуулийн химийн лабораторийг бүрэн тохижуулсан байна.
----	---	--------	--	--------------------------	------	---

**Ажлын байр нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр:**

5.	Тогтвортой хөгжлийг дэмжих ажлын хүрээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа орон нутгийн бизнес эрхлэгчдэд давуу эрх олгох	Жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн Үйлдвэрийн захирал Ц.Ариунжаргал	ХОХБТХ-ийн дарга С.Даваадорж, “Эрдэнэт ШУТП” ОНӨААТҮГ-ын дарга Г.Энхбаяр	Зохион байгуулалтын арга хэмжээ	Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг орон нутгийн ААН, иргэдээс худалдан авсан байна.
6.	Үйлдвэрийн хүний нөөцийн бодлогын шаардлагад нийцсэн зорилтот бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шинээр төгссөн оюутнуудыг түр болон байнгын ажлын байраар хангах, оюутнуудыг дадлагажуулах	Жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн Захиргааны менежер Б.Бадрах-Эрдэнэ	ХХҮГ-ын дарга Х.Эрдэнэбат	Зохион байгуулалтын арга хэмжээ	Орон нутгийн зорилтот бүлгийн иргэд, шинээр төгссөн оюутнууд түр болон байнгын ажлын байраар хангагдаж, оюутнууд дадлага хийх боломж бүрдэнэ.

**Бусад чиглэлээр:**

7.	Байгалийн гамшигт үзэгдэл, олон нийтийг хамарсан цар тахал, бусад шаардлагатай үед үүрэг чиглэлийн дагуу хамтран ажиллах	Жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн Үйлдвэрийн захирал Ц.Ариунжаргал	Аймгийн Онцгой Комиссын нарийн бичгийн дарга Г.Ганбаатар	Зохион байгуулалтын арга хэмжээ	Тусгай зориулалтын машин механизмаар хангах болон бусад төрлийн дэмжлэг үзүүлсэн байна.
8.	Үйлдвэрийн ажилтнуудад төрийн албаны үйлчилгээний талаар сургалт, сурталчилгаа хийх	Жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн Захиргааны менежер Б.Бадрах-Эрдэнэ	ТЗУХ-ийн дарга Ш.Ганболд	Зохион байгуулалтын арга хэмжээ	Төрийн үйлчилгээний талаар ажилтнуудад мэдээлэл хүргэсэн байна.
9.	Тэмдэглэлт өдөр, баярын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах	Жилдээ	“Ачит-Ихт” ХХК-ийн Үйлдвэрийн захирал Ц.Ариунжаргал	ТЗУХ-ийн дарга Ш.Ганболд	15.0	Баярын арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн, хамтран ажилласан байна.
10.	Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, сурталчилах	Жилдээ	Хамтын ажиллагааны хороо	Хамтын ажиллагааны хорооны гишүүд	4.0	Гэрээний явц, хэрэгжилтийн талаар олон нийтэд хүргэж, тэдний оролцоо хангагдсан байна.
<b>Нийт дүн</b>					<b>180.0</b>	